



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 1


Улаанбаатар
хот

**Олборлох үйлдвэрлэлийн ил тод
байдлын тухай санаачилгыг
дэмжих тухай**

Монгол Улсын эдийн засагт уул уурхайн олборлох үйлдвэрүүдийн эзлэх хувийн жин нэмэгдэж цаашид түргэн хурдацтай өсөх хандлагатай байгааг үндэслэн, олон улсын байгууллагууд, хандивлагч орнуудын уриалга, саналыг харгалзан Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Ерөнхий сайд Тони Блэйрийн санаачилсан "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай" санаачилгыг дэмжих нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгыг дэмжсэнтэй холбогдуулан түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Үйлдвэр, худалдааны сайд

Ц.ЭЛБЭГДОРЖ

С.БАТБОЛД

Засгийн газрын 2006 оны 1 дүгээр
тогтоолны хавсралт

**"ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ"
САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ,
ХЯНАН ЗОХИЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд
- Гивүүд: -Үйлдвэр, худалдааны сайд;
-Сангийн сайд;
-Байгаль орчны сайд;
-Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны
дарга (зөвшилцсөнөөр);
-Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын
хорооны дарга (зөвшилцсөнөөр);
-Улсын ерөнхий аудитор (зөвшилцсөнөөр);
-Үндэсний статистикийн газрын дарга
(зөвшилцсөнөөр);
-Улсын мэргэжлийн хяналтын газрын
дарга;
-Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх;
-Уул уурхайн ассоциацийн хүндэт
ерөнхийлөгч (тохиролцсоноор);
-Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх
захирал (тохиролцсоноор).
- Нарийн бичгийн дарга -Ерөнхий сайдын ахлах зөвлөх.

-----000-----